- C. Флавноид
- D. Зүрхний гликозид
- E. Алкалоид

/181./ Жоронд бичигдсэн эмийн ургамлын түүхий эдийг шингэн экстрактаар орлуулахдаа яаж тооцох вэ?

- A. Жоронд бичигдсэн түүхий эдийг хэмжээг 2 дахин ихэсгэж авна
- B. Жоронд бичигдсэн түүхий эдийн хэмжээг 2 дахин багасгаж авна
- C. Жоронд бичигдсэн түүхий эдийн хэмжээтэй адил хэмжээгээр тооцож авна
- D. Жоронд бичигдсэн түүхий эдийн хэмжээ хамаарахгүй
- E. 100 хувиар тооцож авна

/182./ Түүхий эдийн нүхлэг шинж чанарын тодорхойлолтыг заана уу?

- A. Хандлагчийг өөртөө шингээх чадвар
- B. Түүхий эдийн доторх эвдэрсэн эсийн зэрэг
- C. Ургамлын түүхий эд доторх хоосон зай
- D. Жижиглэсэн материалын жижиг хэсгүүдийн хоорондох зай
- E. Түүхий эдийн сиймхий ба нүхлэг шинж чанараас хамаарсан үзүүлэлт

/183./ Этилийн спирт амьтны гаралтай ямар түүхий эдийг даршлахад илүү тохиромжтой вэ?

- A. Өнчин тархи
- B. Нойр булчирхай
- C. Бамбай булчирхай
- D. Өндгөвч
- E. Элэг

/184./ Хандмалуудыг мэдрэхүйн эрхтэний тусламжтайгаар шалгаж үзэхэд ямар шаардлага хангаж байх ёстой вэ?

1. Ургамлын түүхий эдэд агуулагдаж байгаа бодисын үнэр, амтыг хадгалсан байх
2. Нэг төрлийн байдал
3. Тунгалаг байх
4. Спиртийн амттай байх
5. Гашуун амттай байх

/185./ Нэрмэл усаар халаалт хэрэглэж хандлалт явуулахад илрэх дараах хүчин зүйлүүдээс аль нь хандлалтад муугаар нөлөөлөх вэ?

1. Уураг ихээр ялгарах
2. Цардуул хөвмөл үүсгэнэ
3. Салс ялгарна
4. Шингэний хөдөлгөөн идэвхжинэ
5. Коныюктив диффузи нэмэгдэнэ

/186./ Шүүлтийн процессыг идэвхжүүлэх аргуудыг сонго

1. Шүүгдэж буй шингэний дээрээс даралтаар үйлчлэх
2. Шүүгдэж буй шингэний баганы өндрийг нэмэгдүүлэх
3. Шүүгдэж буй шингэний доорос шүүлтэнд агаарын сийрэгжилт үүсгэх
4. Шүүлтийн материалыг нимгэн болгох
5. Шүүгдэж буй шингэний зуурамтгай чанарыг нь багасгах

/187./ Хуурай хандны чанарыг ямар шалгуураар шалгадаг вэ?

1. Чийглэг
2. Хүнд металлын хэмжээ
3. Үйлчлэгч бодисын хэмжээ
4. Ялгамалын нягт
5. Ялгамалын савлагаа

/188./ Хуурай ханд гаргаж авах технологийн схемд аль нь хамарагдах вэ?

1. Хатаах ба хуурай ханд гаргаж авах
2. Стандартчилах
3. Ялгамалыг цэвэрлэх
4. Савлаж хадгалах
5. Ялгамал гаргаж авах

/189./ Түүхий эдийг хэт жижиглэхэд ямар муу талууд илрэх вэ?

1. Хандлагч шингэний нэвтрэн орох процесс муудна
2. Гарган авсан ялгамал булингартана
3. Хандлах процесс удааширна
4. Түүхий эдийн экстрагенттэй хүрэлцэх талбай ихэнэ
5. Түүхий эдийн технологийн шинж чанар сайжирна

/190./ Шинэ галены бэлдмэлүүдийн бусад галены бэлдмэлүүдээс ялгагдах онцлогийг нэрлэ.

1. Биологийн аргаар стандартчилагддаг.
2. Бэлдмэлүүдийг цэвэршүүлэхийн тулд олон төрлийн уусгагчид ашигладаг.
3. Дагалдах бодисуудаас бараг бүрэн цэвэрлэгдсэн, гол үйлчлэгч бодис бараг дангаараа ялгагдсан.
4. Цэвэрлэгээ муу хийгдсэн байdag.
5. Тухайн ургамлын өнгө, үнэр, амтыг хадгалаагүй байдаг

/191./ Тусгайлсан заалт байхгүй бол бүрхүүлгүй шахмал ямар хугацаанд задрах вэ?

- A. 30 мин –аас ихгүй
- B. 10 мин –аас ихгүй
- C. 15 мин –аас ихгүй
- D. 5 мин –аас ихгүй
- E. 3 мин –аас ихгүй

/192./ Бактерцидны лампыг ажил эхлэхээс хэдэн цагийн өмнө ажиллуулах вэ?

- A. 1-2
- B. 3-4
- C. 2-4
- D. 2-3
- E. 4-6

/193./ Шигших процесст нөлөөлөх хүчин зүйлүүд юу вэ?

- 1. Шигшүүрийн нүхний хэлбэр хэмжээ
- 2. Шигшигдэж байгаа материалын үений зузаан
- 3. Шигшигдэж байгаа материалын чийглэг
- 4. Шигшигдэж байгаа материалын хөдөлгөөний хурд
- 5. Шигшүүрийн хөдөлгөөний чиглэл

/194./ Зөөлөн капсулд ямар эмийг туналаж савладаг вэ?

- 1. Мөхлөг
- 2. Паст
- 3. Нуутаг
- 4. Өтгөвтөр шингэн
- 5. Ургамлын түүхий эд

/195./ Үйлдвэрлэлийн байрыг ямар ямар бүс болгон хувааж үздэг вэ?

- 1. Цагаан бүс
- 2. Саарал бүс
- 3. Хар бүс
- 4. Ногоон бүс
- 5. Цэнхэр бүс

/196./ Үрэл эмийн хэлбэрийн давуу талд аль хамарагдах вэ?

- 1. Нарийн зөв тунлагдсан байх
- 2. Эмийн хэлбэрээс эмийн бодис чөлөөлөгдөх хурд маш сайн
- 3. Эмийн бодис нь зохицуулттай чөлөөлөгддөг
- 4. Боломжийн хугацаанд задралд ордог
- 5. Янз бүрийн туслах бодис агуулаагүй

/197./ GMP-ийн шаардлагаар “А” зэрэглэлийн үжилгүй нөхцлийг бүрдүүлвэл аль нь тохирох вэ?

- 1. Турбулент урсгал
- 2. Агаарын ламинар урсгал
- 3. 5 мкм хэмжээтэй жижиг хэсгийн тоо 35000-аас ихгүй
- 4. 1м3 агаарт байх микроорганизмын тоо 1-ээс ихгүй байх
- 5. м2 байх микроорганизмын тоо 10000-аас бага байх

/198./ Шахмал эмийн хэлбэрийн давуу талд аль хамаарах вэ?

- 1. Хадгалах явцад задралт нь удааширдаг
- 2. Хадгалах явцад хатуурч цемент шиг болдог
- 3. Бүх өвчтөнгүүд хэрэглэж болдоггүй
- 4. Нарийн тунлагдсан
- 5. Концентраттай уусмал үүсч салстыг цочроодог

/199./ Хатуу капсулд ямар эмийг савладаг вэ?

- 1. Ургамлын хуурай ханд
- 2. Нуутаг
- 3. Мөхлөг
- 4. Микропранул
- 5. Паст

/200./ II зэргийн цэвэршилтийн түвшинд технологийн ямар ажилбарыг хийх вэ?

- 1. Уусмал найруулах

2. Уусмал шүүх
3. Тун шил флакон угаах
4. Хатаах
5. Ариутгах

/201./ Дараах баримт бичгүүдийн алийг нь эмийн үйлдвэрт шууд хэрэглэдэг вэ?

1. Мастерийн журнал
2. Үйлдвэрлэлийн зөв арчилгааны зааварчилгаа
3. Технологийн заавар
4. Бэлэн бүтээгдэхүүний заавар
5. Үйлдвэрийн схем

/202./ Хатуу болон зөөлөн капсулыг ямар аргаар гарган авдаг вэ?

1. Дүрэх арга
2. Дуслын арга
3. Хэвлэх
4. Хөөлгөх
5. Өнхрүүлэх

/203./ Хатуу желатинан капсулыг гарган аваходаа дүүрэн аргыг хэрэглэдэг. Энэ арга нь тогтмол температуртай желатины уусмалд тэнхлэгээрээ эргэлдэх олон тооны металл хэвийг дүрээд аваходаа капсул хэлбэр үүсэгэхэд үндэслэгддэг.

/204./ Зарим тарилгын уусмалыг ариутгах үед температурын нөлөөгөөр хими-физикийн өөрчлөлтөд ордог. Ийм учраас түүнийг тогтворжуулах зорилгоор антиоксидант бодис нэмдэг.

/205./ Тарилгын эмийн хэлбэрийг бэлтгэхэд хүйтэн аргаар гарган авсан ургамалын шингэн тосыг хэрэглэдэг. Учир нь хүчлийн тоо их байвал мэдрэлийн төгсгөлийг цочроож тарихад өвдөлт үүсгэж болно.

/206./ Нэгэн жигд ширхэгтэй элсэн чихрийн ширхэгээр үрлийн цөмийг бэлтгэдэг. Учир нь жигд бус ширхэгтэй сахах авбал үрлийн цөм бэлтгэх явцад хэлбэр, дурс, хэмжээ нь өөрчлөгдж үрлийн чанарт муугаар нөлөөлдөг.

/207./ Бүх материал бүтээгдэхүүнийг хадгалахдаа хамгийн түрүүнд дотогш оруулах, хамгийн түрүүнд гадагш гаргах салаавчилсан дүрмийг баримталж байршуулна. Учир нь үйлдлийн дэс дараалалыг зөв баримтлахад зохистой байдаг

/208./ Туншилний бүрэн байдлыг шалгахдаа ямар уусмалд шалгах вэ?

- A. Спиртийн уусмалд
- B. Хлорамины уусмалд
- C. Нэрмэл усанд
- D. Метилен хөхийн уусмалд
- E. Фурациллины уусмалд

/209./ Хэрэв тусгайлан заалт байхгүй бол бүрхүүлтэй шахмал эм ямар хугацаанд задрах вэ?

- A. 15 мин-аас ихгүй
- B. 30 мин-аас ихгүй
- C. 5 мин-аас ихгүй
- D. 10 мин-аас ихгүй
- E. 3 мин-аас ихгүй

/210./ Нунтагийн асгараах жин гэдэг тодорхойлолтын хамгийн зөвийг сонгоно уу?

- A. Чөлөөтэй асгараах нунтагийн нэгж эзлэхүүн дэх жинг хэлнэ
- B. Нунтаг бодисын хүндийн жинг хэлнэ
- C. Нунтаг бодисын хувийн жинг хэлнэ
- D. Чөлөөтэй асгараах нунтагийн жинг хэлнэ
- E. Нунтаг бодисын нягтыг хэлнэ

/211./ Үйлдвэрийн ердийн гэрэлтүүлэг хэд вэ? Зөв хариултыг сонгоно уу?

- A. 450 люкс
- B. 350 люкс

- C. 300 люкс
- D. 265 люкс
- E. 500 люкс

/212./ Тун шилтэй тарилгын уусмалын дүүргэлтийг ямар аргаар шалгах вэ?

- A. Вакуумын аргаар
- B. Хар цагаан дэлгэцэн дээр үзэх
- C. Шприцийн аргаар
- D. Ижил хэмжээний уусмалтай харьцуулж
- E. Микроскопоор

/213./ Нунтагийн шахагдах чадвар гэдэг тодорхойлолтын хамгийн зөвийг олно уу?

- A. Нунтаг эмийн бодисын бат бөх бүтэцтэй систем үүсгэх чадварыг хэлнэ
- B. Нунтаг бодисын нягтрах чадварыг хэлнэ
- C. Нунтаг эмийн бодисын бат бөх бүтэцтэй, холбоот дисперсийн систем үүсгэх чадварыг хэлнэ
- D. Нунтаг бодисын янз бүрийн нөхцөлд шахагдах чадварыг хэлнэ
- E. Нунтаг бодисын янз бүрийн бодистой хамт шахагдах чадварыг хэлнэ

/214./ 1-р зэрэглэлийн цэвэршилттэй өрөөнд дараах үйлдлүүдийн алийг нь хийх вэ?

- A. Туслах материалыг угааж ариутгах
- B. Уусмалыг савлах
- C. Туншил үйлдвэрлэх
- D. Уусмал найруулах
- E. Уусмал ариутгах

/215./ Д зэрэглэлийн өрөөнд дараах ажлуудын алийг нь хийх вэ?

- A. Уусмал найруулах
- B. Туншил угаах
- C. Дрот угаах
- D. Туншил дүүргэх
- E. Хувцас солих

/216./ Туншилтэй тарилгынуусмалын өнгийг ямар аргаар шалгах вэ?

- A. Микроскопоор шалгаж
- B. Метилен хөхийн уусмалд хийж
- C. Эталон уусмалтай харьцуулж
- D. Нэрмэл устай харьцуулж
- E. Рентген туяаны тусламжтайгаар

/217./ Нунтагийн урсах чанар гэдэг тодорхойлолтын хамгийн зөвийг сонгоно уу?

- A. Нунтаг эмийн бодисын урсах чанарыг хэлнэ
- B. Нунтаг бодисын гоожих чадварыг хэлнэ
- C. Нунтаг бодисын янз бүрийн бодистой хамт урсах чадварыг хэлнэ
- D. Нунтаг эмийн бодис нь өөрийнхөө хүндийн жингээр гоожих чадварыг хэлнэ
- E. Тодорхой эзлэхүүнтэй нунтагийн урсах чадварыг хэлнэ

/218./ Барбитал натрийн тооны тодорхойлолтыг сонго.

- A. Иодометр
- B. Ацидиметр
- C. Тунадасжуулах
- D. Морын арга
- E. Алкалиметр

/219./ Нэрмэл усанд нитрит, нитратын хольц байгаа эсэхийг ямар урвалаар илрүүлэх вэ?

- A. Калийн перманганатын уусмалын өнгийг арилгах
- B. Хүхрийн хүчлийн орчинд перманганат калийн өнгө арилгах
- C. Дифениламины уусмалтай хөх өнгө өгнө
- D. Хүхрийн хүчлийн орчинд перманганат калийн өнгө арилахгүй

Е. Дифениламины уусмалтай хөх өнгө өгөхгүй.

/220./ Мөнгөний ион ба хлорын ионы хооронд явагдах урвал дээр үндэслэгдсэн, ажлын уусмал нь мөнгөний нитрат, индикатор нь кали хромат хэрэглэгддэг аргыг сонго.

- A. Фаянсын арга
- B. Фольгардын арга
- C. Морын арга
- D. Меркуриметр
- E. Тунадасжуулах

/221./ Усанд аль эм хялбар уусдаг вэ?

- 1. Фенилсалицилат
- 2. Ацетилсалицилийн хүчил
- 3. Тимол
- 4. Новокайн
- 5. Резорцин

/222./ Эргокальциферолыг гэрлээс болон агаарын хүчилтөрөгч орохоос хамгаалан хадгалдагийн учир нь юу вэ?

- 1. Гэрлийн нөлөөгөөр холекальциферол үүснэ
- 2. Агаарын хүчилтөрөгч нь витамин D исэлдүүлнэ
- 3. Агаарын хүчилтөрөгч нь витамин D ангижруулна
- 4. Гэрлийн нөлөөгөөр хортой токсистерин үүснэ.
- 5. Өөрчлөгдөхгүй.

/223./ Өнчин тархины гормонуудыг нэрлэнэ үү?

- 1. Питунтрин
- 2. Вазопрессин
- 3. Окситоцин
- 4. Инсулин
- 5. Адреналин

/224./ Үндэсний болон олон улсын фармакопейн заалтууд ямар шинжийг агуулах вэ?

- 1. Үндэсний болон олон улсын фармакопейн заалтыг заавал мөрдөнө.
- 2. Үндэсний фармакопейн заалтыг тухайн оронд заавал мөрдөнө.
- 3. Олон улсын ба үндэсний фармакопейн заалт нь зөвлөх шинж чанартай
- 4. Олон улсын фармакопейн заалт нь зөвлөх шинж чанартай.
- 5. Олон улсын фармакопейн бүх оронд заавал мөрдөнө

/225./ Титрийн уусмалыг яаж бэлтгэх вэ?

- 1. Концентрацитай уусмалаас
- 2. Химиин цэвэр бодисоос фармакопейн дагуу
- 3. Сулруулсан уусмалаас
- 4. Фиксаналаас
- 5. Уусмалаас

/226./ Формальдегидыг исэлдүүлэх урвалд оруулахад улаан тунадас үүсэв. Учир нь исэлдүүлэх урвалын дүнд Cu₂O үүснэ.

/227./ Аскорбины хүчлийн уусмалыг тогтвортжуулахын тулд натрийн метагидросульфат эсвэл натрийн сульфат тулд нэмж өгнө. Учир нь аскорбины хүчил агаар металл, хүчил шүлтийн нөлөөгөөр амархан исэлддэг.

/228./ Формальдегидыг исэлдүүлэх урвалд оруулахад улаан тунадас үүсэв. Учир нь исэлдүүлэх урвалын дүнд Ag үүснэ.

/229./ Аскорбины хүчлийн уусмалыг тогтвортжуулахын тулд натрийн метагидросульфат эсвэл натрийн сульфит нэмж өгнө. Учир нь аскорбины хүчил агаар металл, хүчил шүлтийн нөлөөгөөр амархан ангижирдаг

/230./ Морын арга гэдэг нь мөнгөний ион, хлорын ионы хооронд явагдах урвал дээр үндэслэгдсэн арга . Учир нь титрийн уусмал нь 0,1N мөнгөний нитрат.

/231./ Аналгины тооны тодорхойлолт аль нь вэ?

- A. Аргентометр
- B. Иодометр
- C. Перманганатометр
- D. Нитритометр
- E. Алкалиметр

/232./ Өвөрмөц үнэртэй металл шиг гялалзсан хар саарал өнгийн ялтас хэлбэрийн талст. Энэ ямар бодис вэ?

- A. Калийн бром
- B. Иод
- C. Мөнгөний нитрат
- D. Марганец
- E. Кали

/233./ Калийн йодидыг калийн хлорид ба калийн бромидоос дараах урвалын алинаар нь ялгах вэ?

А. Давсны хүчлийн орчинд хлорамин, хлороформтой урвалд оруулахад бор шар өнгө үүснэ.

Б. Давсны хүчлийн орчинд натрийн нитрит, хлороформтой урвалд оруулахад улаан ягаан өнгө үүснэ.

С. Төмрийн (III) хлоридоор үйлчлэхэд улаан ягаан өнгө үүснэ.

Д. Төмрийн (II) хлоридоор үйлчлэхэд улаан ягаан өнгө үүснэ.

Е. Ялгах боломжгүй.

/234./ Нэрмэл ус саармаг орчинтой байх ёстой. Үүнийг тодорхойлоход дараах индикаторуудын алийг нь сонгох вэ?

- A. Фенолфталейн
- B. Метил улаан
- C. Метил хөх
- D. Метил улбар
- E. Тропеолон-оо

/235./ Натри хлоридыг таних чанарын урвалуудыг сонго.

А. Барийн сульфатын уусмалтай цагаан тундас үүснэ

Б. Цинк-уранил ацетатын уусмалтай шар тундас үүснэ

С. Мөнгөний нитратын уусмалтай шар тундас үүснэ

Д. Барийн хлоридын уусмалтай цагаан тундас үүснэ.

Е. Цинк-уранил ацетатын цагаан тунадас үүснэ

/236./ Кальци хлоридын тооны тодорхойлолтыг хийхэд ямар аргыг сонгох вэ?

- A. Саармагжуулах арга
- B. Исэлдэн ангижруулах арга
- C. Комплексонометрийн арга
- D. Ацидиметр
- E. Иодометр

/237./ Натрийн карбонатын уусмалыг натрийн гидрокарбонатын уусмалаас хэрхэн ялгах вэ?

- A. Лакмусын индикатор
- B. Фенолфталейны индикатор
- C. Метил улаан индикатор
- D. Цууны хүчилтэй явагдах урвалаар
- E. Эрдэс хүчилтэй явагдах урвалаар

/238./ Уротропин юунд уусах вэ?

- A. Ус, спиртэнд уусна
- B. Ус эфирт уусна.

- C. Ус, спиртэнд уусахгүй
- D. Усанд уусахгүй, спиртэнд уусна.
- E. Усанд уусахгүй эфирт уусна.

/239./ Үл мэдэгдэх эмийн бодис руу мөнгөний нитрат нэмэхэд цагаан тунадас үүсэв. Ямар анион байсан бэ?

- A. Ацетат
- B. Хлорид
- C. Иодид
- D. Сульфат
- E. Бромид

/240./ Аскорбины хүчил нь мөнгөний нитраттай ямар өнгөтэй тунадас үүсгэх вэ ?

- A. Саарал
- B. Цагаан
- C. Шар
- D. Бор
- E. Ягаан

/241./ Цайр, кальци, магнийн тооны тодорхойлолтыг ямар аргаар хийх вэ?

- A. Роданометр
- B. Комплексонометр
- C. Тунадасжуулах
- D. Саармагжуулах
- E. Меркуриметр

/242./ Натрийн бромидын тооны тодорхойлолтыг хийхэд дараах аргуудын алийг нь сонгох вэ?

- A. Иодометр
- B. Комплексонометр
- C. Аргентометр
- D. Саармагжуулах
- E. Нитритометр

/243./ Эмийн бодисын уусалтыг ГФ.XI -ийн дагуу тодорхойлоход 1гр бодисыг 15мл өгөгдсөн уусгагчдад хийж 18-220С-ийн хэмд сэгсэрэхэд 10 минутанд уусч байвал уусалт нь ямар бодис гэх вэ?

- A. Хялбар
- B. Маш хялбар
- C. Уусдаг
- D. Муу уусдаг
- E. Маш муу уусдаг

/244./ Урвуу титрлэлт гэж юу вэ?

- A. Тодорхойлох бодистой ажлын уусмалыг шууд хийх.
- B. Тодорхойлох бодисыг ямар нэгэн урвалж бодистой урвалд оруулж бүтээгдэхүүнийг ажлын уусмалаар титрлэх.
- C. Тодорхойлох бодисыг ямар нэгэн урвалж бодистой урвалд оруулж илүүдлийг титрлэнэ.
- D. Тодорхойлох бодис руу мэдэгдэж буй концентрацитай уусмалыг илүүдлээр нэмж үлдэгдэлийг нь ажлын уусмалаар титрлэнэ
- E. Тодорхойлох бодис руу ямар нэгэн концентрацитай уусмалыг илүүдлээр нэмж үлдэгдэлийг нь ажлын уусмалаар титрлэнэ

/245./ Нэрмэл усны орчинг сонго.

- A. PH 3,0-4,3
- B. PH 5,4 - 7,5
- C. PH 5,0-6,8
- D. PH 6.5-7.0

Е. РН 7.0-7.5

/246./ Комплексонометрийн аргад ямар индикаторуудыг хэрэглэх вэ?

1. Эрихром хар
2. Хүчиллэг хром хар хөх
3. Мурексид
4. Фенолфталеин
5. Метил улаан

/247./ Нитритометрийн аргад ямар индикаторуудыг хэрэглэдэг вэ?

1. Фенолфталейн
2. Тропеолин ОО
3. Метилийн улаан
4. Йод цардуулын цаас
5. Метилийн хөх

/248./ Цефалоспорины антибиотик эмүүдийг нэрлэнэ үү?

1. Цефазолин
2. Цефалоризин
3. Клафоран
4. Фортум
5. Клоксациллин

/249./ Дараах эмүүдээс аль нь усанд уусдаггүйг нэрлэнэ үү?

1. Адреналины гидрохлорид
2. Скопаламины гидробромид
3. Гоматропины гидробромид
4. Барийн сульфат
5. Морфины гидрохлорид

/250./ Эуфиллины бүтэц найрлага аль нь вэ?

1. Теофиллин +ベンзоат натри
2. Кофейн+этилендиамин
3. Теобромин+этилендиамин
4. Теофиллин + этилендиамин
5. Теобромин+бензоат натри

/251./ Сулруулсан давсны хүчлийн уусмалыг дараах заалтын алинд нь хэрэглэдэггүй вэ?

1. Ходоодны хүчил багадсан үед
2. Цус багадалтанд төмрийн бэлдмэлийг хэрэглэх үед
3. Хоолны шингэц муудсан үед пепсинтэй холимог шингэнээр
4. Ходоодны хүчил ихэдсэн үед
5. Төмрийн бэлдмэл хэрэглэх үед

/252./ Этилийн спиртийн градусыг хэмжих багаж аль нь вэ?

1. Термометр
2. Спиртомер
3. Рефрактометр
4. Денсиметр
5. Поляриметр

/253./ Фармакопейн заалтаар эмийн бэлдмэлүүдээс алиныг нь танихад төмрийн хлорид (III) – ыг урвалж болгон хэрэглэхээр заасан вэ?

1. Бромидууд
2. Ацетатууд
3. Йодидууд
4. Бензоатууд
5. Фосфатууд

/254./ Бамбай булчирхайн гормонуудаас нийлэг эмийг нэрлэнэ үү?

1. Тиреоидин
2. Дийодтирозин
3. Инсулин
4. Бетазин
5. Тироксин

/255./ Дараах нэгдлүүдээс аль нь усанд хялбар уусах вэ?

1. Аминазин
2. Тиамины бромид
3. Рибофлавин
4. Аскорбины хүчил
5. Ретинол

/256./ Хүн орхоодойн үндэсний ханд нь хөөсрүүлэх урвал өгнө. Учир нь үндсэнд нь тритерпений сапонин агуулагдана.

/257./ 2 гэрт халгайн навчийг умай, гэдэс, уушигны цус алдалтын үед цус тогтоох зорилгоор хэрэглэдэг. Халгайн навчинд витамин К агуулагдана.

/258./ Усан ялгамлыг сэгсрэхэд тогтвортой хөөс үүсч байгаа нь ямар бодис агуулагдсаны шинж вэ

- А. Флавоноид
- Б. Сапонин
- С. Эфирийн тос
- Д. Салс
- Е. Аргаах бодис

/259./ Эмийн багваахайн эмчилгээний үйлдлийг сонго.

- А. Даралт бууруулах
- Б. Цус тогтоох
- С. Шээс хөөх
- Д. Үрэвслийн эсрэг
- Е. Хоол боловсруулах эрхтний үйл ажиллагааны хямрал

/260./ Гүүний саамны эмнэлэг биологийн ач холбогдол

- А. Мэдрэлийн өвчин
- Б. Элэгний хорыг арилгах
- С. Нойргүйдэх өвчин
- Д. Бөөрний үйл ажиллагаа сайжруулах
- Е. Үе мөчний өвчний үед өвдөлт намдаах

/261./ Үхэр мэхээрийн химийн бүрэлдэхүүн

- А. Эфирийн тос
- Б. Флаванойд
- С. Аргаах бодис
- Д. Салс
- Е. Аскорбины хүчил

/262./ Тосонд уусдаг витаминыг нэрлэ.

- А. A, D, E, K
- Б. C, P, PP, B
- С. PP, B, A, D,
- Д. C, P, E, K
- Е. P, PP, A, B

/263./ Ямар зүрхнийг ликозид нь биед хуримтлагдан хортой нөлөө үзүүлэх нь бага байдаг вэ?

- А. Улаан хуруувчин цэцэг
- Б. Май цэцэг
- С. Том цэцэгт хуруувчин цэцэг
- Д. Хаврын алтан хундага

Е. Үсэрхэг хуруувчин цэцэг

/264./ Чихэр өвсний ямар түүхий эдийг хэрэглэх вэ?

- A. Өвс
- B. Үр жимс
- C. Үндэс
- D. Цэцэг
- E. Өвс

/265./ Пагдгар бадааны түүхий эдийг сонго.

- A. Үр жимс
- B. Цэцэг
- C. Навч
- D. Үндэс ба үндэслэг иш
- E. Өвс

/266./ Эмийн алтайн латин нэр.

- A. Radix Althaeaee
- B. Allium Althacum
- C. Althaea officinalis
- D. Cummi Armeniacae
- E. Linum usitatissimum

/267./ 2 гэрт халгайн түүхий эдийг олно уу?

- A. Цэцэг
- B. Иш
- C. Үндэс
- D. Навч
- E. Өвс

/268./ Ургамлаас ялгаж авсан билемахбодид эмчилгээний үйлдэлүзүүлэх тухайн бүлэг бодисыг бодис гэнэ.

- A. Хам бодис
- B. Дагалдах бодис
- C. Үйлчлэгч бодис
- D. Эмийн бодис
- E. Үндсэн бодис

/269./ Ургамлын гаралтай гадаргуугийн идэвхтэй цусны улаан бөөмийг задлах чадвартай, азотгүй, гликозид бүтэцтэй байгалийн томоохон нэгдлийггэнэ.

- A. Антrocены уламжлал
- B. Гашуун гликозид
- C. Сапонин
- D. Кумарин
- E. Флавоноид

/270./ Ургамалд үүсэж бий болдог усны уураар нэрэгддэг, дэгдэмхий үнэрт нэгдэл

- A. Аргаах бодис
- B. Салс
- C. Өөх тос
- D. Сапонин
- E. Эфирийн тос

/271./ Эмийн ургамлын түүхий эд (ЭУТЭ)-ийг хэдийд түүвэл зохих вэ?

- A. Нартай халуун өдөр
- B. Тухайн ургамлын онцлогоос хамаарч харилцан адилгүй
- C. Хур тунадасгүй үед
- D. Өглөөний сэргүүн байх үед

Е. Шүүдэр хатасны дараа

/272./ Бугын цусан эврэнд агуулагдах эмт бодисыг сонго

- A. Сапонин
- B. Ледол
- C. Эфедрин
- D. Пантокрин
- E. Салс

/273./ Сибирийн зүрхэн цэцэг ямар овгийн ургамал вэ?

- A. Polygalaceae
- B. Fabaceae
- C. Equisetaceae
- D. Rosaceae
- E. Malvaceae

/274./ Витаминыг уусалтаар нь

- 1. Тусгай химиин бодист уусдаг
- 2. Тосонд уусдаг
- 3. Органик уусгагчинд уусдаг
- 4. Усанд уусдаг
- 5. Хүчилд уусдаг

/275./ Алкалойдуудын гүйцэтгэх үүрэг нь?

- 1. Фотосинтезийн процесст зайлшгүй шаардлагатай
- 2. Өсөлт хөгжлийг сайжруулах
- 3. Ургамлыг эрүүлжүүлэх
- 4. Нөхөн төлжүүлэх
- 5. Амьсалах

/276./ Ургамлын газар доорх эрхтнийг хэдийд түүж бэлтгэх вэ?

- 1. Газрын дээрх хэсэг нь цэцэглэх үеэр
- 2. Хавар эрт
- 3. Ургамлын шүүс гүйдлийн үе
- 4. Намар
- 5. Хэдийд ч болно

/277./ Органик нэгдлүүдэд юу юу хамаарах вэ?

- 1. Нүүрс ус
- 2. Сахар
- 3. Амин хүчил
- 4. Ус
- 5. Микроэлемент

/278./ Ургамлын анхдагч боловсруулалтын бүтээгдэхүүнийг нэрлэнэ үү.

- 1. Эфирийн тос
- 2. Камедь
- 3. Салс
- 4. Θөх тос
- 5. Сүүн шүүс

/279./ Нохойн хошууны гол үйлчлэгч бодис аль нь вэ

- 1. Аскорбины хүчил
- 2. Каротин
- 3. Витамин
- 4. Сахар
- 5. Органик хүчил

/280./ Нохойн хошууны жимсийг $20^{\circ}35^{\circ}\text{C}$ хатаана. Нохойн хошуунд эфирийн тос агуулагдана.

/281./ Аргаах бодис нь бага молекулт нэгдэл. Учир нь суурилаг шинж чанартай азот агуулсан.

/282./ Чацарганы тосыг цацраг идэвхт туюаны гэмтэл, ходоод, умайн хүзүү, үтрээний шархлаанд хэрэглэдэг. Учир нь тосонд агуулагдах токоферол нь амьд эсийн мембранийг гэмтэхээс хамгаална.

/283./ Эмийн үйлдэл гэж юу вэ?

- A. Хүний болон мал амьтны өвчинөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зорилгоор зохиц тунгаар хэрэглэхэд бие махбодид гарч болзошгүй болон гарч байгаа сөрөг илрэл.
- B. Эм нь бие махбодид үйлчилж үйл ажиллагааг түр зуур өөрчлөхийг хэлнэ.
- C. Эмийн бэлдмэл хэрэглэхэд бие махбодитой харилцан үйлчлэлийн үр дүн
- D. Хүний болон мал амьтны өвчинөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зорилгоор зохиц тунгаар хэрэглэхэд бие махбодид тогтмол гардаг сөрөг илрэл.
- E. Хүний болон мал амьтны өвчинөөс урьдчилан сэргийлэх, оношлоход бие махбодид гарч болзошгүй болон гарч байгаа сөрөг илрэл.

/284./ Элэг хамгаалах эмийг сонгоно уу.

- A. Гордохс
- B. Мезим-Форте
- C. Эссенциал
- D. Церукал
- E. Фенамин

/285./ Валидол, Глицерил тринитратыг ямар аргаар хэрэглэх вэ?

- A. Уух
- B. Хэлэн дор тавьж шимэх
- C. Шулуун гэдсэнд хийх
- D. 12 хуруу гэдсэнд зондоор хэрэглэх
- E. Тарих

/286./ Эм судлал юуг судлах вэ?

- A. Эмийн бодис ба биологийн объектийн харилцан үйлчлэлийг судлана.
- B. Эмийн бодис ба хүний биеийн харилцан үйлчлэлийг судлана.
- C. Эм бие махбодид хэрхэн үйлчлэхийг судална.
- D. Эмийн бодис бие махбодиос ялгараахыг судална
- E. Эмийн бодис бие махбодид орох замыг судална

/287./ Бөөлжилтийн эсрэг эмийг сонгоно уу

- A. Гордохс
- B. Мезим-Форте
- C. Эссенциал
- D. Церукал
- E. Фенамин

/288./ Эм гэж юу вэ?

- A. Эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэдэг химийн өвөрмөц нэгдэл юм.
- B. Эмчилгээний буюу урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагатай үр нөлөө гаргахын тулд эмийн зүйлийг хэрэглэхэд тохиromжтой хэлбэрт оруулсаныг хэлнэ.
- C. Эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх нэг буюу хэд хэдэн эмийн бодисыг хэлнэ.
- D. Эмийн зүйлийг тодорхой хэлбэрт оруулж тугнасаныг эмийн бэлдмэл гэнэ.
- E. Хүний болон мал, амьтны өвчинөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, дархлаажуулах зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэл зүйн сорилт туршилтаар нотлогдсон нийлэг буюу амьтан, ургамал, эрдсийн гаралтай бодисыг тодорой хэлбэрт оруулсан, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг бэлдмэл.

/289./ Фармакодинамик гэж юу вэ?

- A. Эмийн бодисын бие махбодод шимэгдэх, тархах, хувирах үйл явц юм.

В. Эмийн бодисын бие махбодод шимэгдэх, тархах, хувирах өөрчлөгдөх, ялгаран гарах үйл явц юм.

С. Эмийн бодисын үйлдэлийн шинж чанар, байршил, механизм юм

Д. Эмийн бодисын бие махбодид өөрчлөгдөх үйл явц юм.

Е. Эмийн бодисын бие махбодид тархах үйл явц юм

/290./ Эмийн үйлдэлийн механизм гэж юу вэ?

А. Хүний болон мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зорилгоор зохиц тунгаар хэрэглэхэд бие махбодид гарч болзошгүй болон гарч байгаа сөрөг илрэл.

Б. Эм нь бие махбодийн үйл ажиллагаанд нөлөөлж түүнийг түр зуур өөрчлөхийг хэлнэ

С. Эмийн бэлдмэл хэрэглэхэд бие махбодитой харилцан үйлчлэл.

Д. Хүний болон мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зорилгоор зохиц тунгаар хэрэглэхэд бие махбодид тогтмол гардаг сөрөг илрэл

Е. Хүний болон мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлоход бие махбодид гарч болзошгүй болон гарч байгаа сөрөг илрэл.

/291./ Нойр булчирхайн шүүрэл ялгарал ихэссэн үед хэрэглэх эмийг сонгоно уу.

А. Гордокс

В. Мезим-Форте

С. Эссенциал

Д. Церукал

Е. Фенамин

/292./ Тальк, идэвхижүүлсэн нүүрс зэрэг нь аль эмийн бүлэгт хамаарах вэ?

А. Хэсгийг мэдээгүйжүүлэх эм

Б. Аргаах эм

С. Шингээх эм

Д. Бүрхээх эм

Е. Татах эм

/293./ Либексиныг ямар зорилгоор хэрэглэх вэ?

А. Өвдөлт намдаах

Б. Амьсгал сэргээх

С. Цэр ховхлох

Д. Ханиалга намдаах

Е. Халуун бууруулах

/294./ Эмчилгээний тун гэж юу вэ?

А. Бие махбодид эмчилгээний зайлшгүй үр нөлөө үзүүлж чадах эмийн бодисын хэмжээг эмчилгээний тун гэнэ.

Б. Бие махбодид эмчилгээний үр нөлөө үзүүлхүйц эмийн бодисын хэмжээг эмчилгээний тун гэнэ

С. Бие махбодид эмчилгээний үр нөлөө үзүүлэх магадлалтай эмийн бодисын хэмжээг эмчилгээний тун гэнэ

Д. Бие махбодид эмчилгээний үр нөлөө үзүүлэх боломжтой эмийн бодисын хэмжээг эмчилгээний тун гэнэ

Е. Бие махбодид үйлдэл үзүүлж чадах эмийн бодисын хэмжээг эмчилгээний тун гэнэ.

/295./ Эмийн бэлдмэл гэж юу вэ?

А. Эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэдэг химийн өвөрмөц нэгдэл юм.

Б. Эмчилгээний буюу урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагатай үр нөлөө гаргахын тулд эмийн зүйлийг хэрэглэхэд тохиромжтой хэлбэрт оруулсаныг хэлнэ.

С. Эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх нэг буюу хэд хэдэн эмийн бодисыг хэлнэ.

Д. Эмийн зүйлийг тодорхой хэлбэрт оруулж тугнасаныг эмийн бэлдмэл гэнэ

Е. Хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, дархлаажуулах зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэл зүйн сорилт туршилтаар нотлогдсон нийлэг буюу амьтан, ургамал, эрдсийн гаралтай бодисыг тодорой хэлбэрт оруулсан, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг бэлдмэл.

/296./ Фармакокинетик гэж юу вэ?

А. Эмийн бодисын бие махбодод шимэгдэх, тархах, хувирах үйл явц юм.

Б. Эмийн бодисын бие махбодод шимэгдэх, тархах, хувирах өөрчлөгдөх, ялгаран гарах үйл явц юм.

С. Эмийн бодисын бие махбодиос ялгаран гарах үйл явц юм.

Д. Эмийн бодисын бие махбодид өөрчлөгдөх үйл явц юм.

Е. Эмийн бодисын бие махбодид тархах үйл явц юм.

/297./ Эмийн гаж нөлөө гэж юу вэ?

А. Хүний болон мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зорилгоор зохиц тунгаар хэрэглэхэд бие махбодид гарч болзошгүй болон гарч байгаа сөрөг илрэл

Б. Эм нь бие махбодид үйлчилж үйл ажиллагааг түр зуур өөрчлөхийг хэлнэ.

С. Эмийн бэлдмэл хэрэглэхэд бие махбодитой харилцан үйлчлэл.

Д. Хүний болон мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зорилгоор зохиц тунгаар хэрэглэхэд бие махбодид тогтмол гардаг сөрөг илрэл

Е. Хүний болон мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношпоход бие махбодид гарч болзошгүй болон гарч байгаа сөрөг илрэл

/298./ Бромгексин аль бүлгийн эм бэ?

А. Ханиалга намдаах

Б. Цэр шингэлэх

С. Цэр ховхлох

Д. Амьсгал сэргээх

Е. Өвдөлт намдаах

/299./ Эмийн бодис гэж юу вэ?

А. Эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэдэг химиин өвөрмөц нэгдэл юм.

Б. Эмчилгээний буюу урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагатай үр нөлөө гаргахын тулд эмийн зүйлийг хэрэглэхэд тохиromжтой хэлбэрт оруулсаныг хэлнэ.

С. Эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх нэг буюу хэд хэдэн эмийн бодисыг хэлнэ.

Д. Эмийн зүйлийг тодорхой хэлбэрт оруулж тугнасаныг эмийн бэлдмэл гэнэ

Е. Хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, дархлаажуулах зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэл зүйн сорилт туршилтаар нотлогдсон нийлэг буюу амьтан, ургамал, эрдсийн гаралтай бодисыг тодорой хэлбэрт оруулсан, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг бэлдмэл.

/300./ Нойр булчирхайн шүүрэл ялгарал багассан үед хэрэглэх эмийг сонгоно уу.

А. Гордокс

Б. Мезим-Форте

С. Эссенциал

Д. Церукал

Е. Фенамин

/301./ Эмийн тун гэж юу вэ?

А. Эмийн бодисын хэрэглэх хэмжээг тун гэнэ.

Б. Эмийн бодисын нэгжийг тун гэнэ.

С. Бие махбодид жин, эзэлхүүн, үйлдлийн нэгжээр хэмжиж оруулах эмийн бодисын үйлдэлийг тун гэнэ.

Д. Бие махбодид оруулах эмийн бодисын хэмжээг эмийн тун гэнэ

Е. Бие махбодид жин, эзэлхүүн, үйлдлийн нэгжээр хэмжиж оруулах эмийн бодисын хэмжээг эмийн тун гэнэ.

/302./ Эмийн зүйл гэж юу вэ?

А. Эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэдэг химийн өвөрмөц нэгдэл юм.

В. Эмчилгээний буюу урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагатай үр нөлөө гаргахын тулд эмийн зүйлийг хэрэглэхэд тохиromжтой хэлбэрт оруулсаныг хэлнэ

С. Эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх нэг буюу хэд хэдэн эмийн бодисыг хэлнэ.

Д. Эмийн зүйлийг тодорхой хэлбэрт оруулж түгнасаныг эмийн бэлдмэл гэнэ.

Е. Хүний болон мал, амьтны өвчинеэс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, дархлаажуулах зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэл зүйн сорилт туршилтаар нотлогдсон нийлэг буюу амьтан, ургамал, эрдсийн гаралтай бодисыг тодорой хэлбэрт оруулсан, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг бэлдмэл.

/303./ Эмийн үйлдэлийг сонгоно уу.

1. Хэсэг газрын

2. Ерөнхий

3. Рефлексийн

4. Сонгомол

5. Гаж

/304./ Ходоодны булчирхайн шүүрэл ихэссэн үед хэрэглэх эмийг хэд ангилах вэ?

1. Ходоодны булчирхайн шүүрлийг багасгах эм

2. Ходоодны хүчил саармагжуулах эм

3. Ходоод хамгаалах эм

4. Ходоодны шүүрлийг нэмэгдүүлэх эм

5. Ходоодны булчинг сулруулах эм

/305./ Аргаах эмийг ямар зорилгоор хэрэглэх вэ?

1. Үрэвслийн эсрэг

2. Суулгалт тогтоох

3. Хортой бодисын шимэгдэлт зогсоох

4. Өвдөлт намдаах

5. Цочроох

/306./ Эмэнд тавигдах шаардлагыг сонгоно уу

1. Үр дүнтэй

2. Аюулгүй

3. Хүртээмжтэй

4. Хэрэглэхэд хялбар

5. Сонголттой

/307./ Эмийн эмчилгээний тунг хэрхэн ангилах вэ?

1. Эмчилгээний бага тун

2. Эмчилгээний дунд тун

3. Эмчилгээний дээд тун

4. Эмчилгээний доод тун

5. Эмчилгээний харьцангуй тун

/308./ Эмийн үйлдэл юунаас хамаарах вэ?

1. Нас

2. Хүйс

3. Удамшлын хүчин зүйл

4. Бие махбодийн байдал

5. Хоногийн хэмнэл

/309./ Эмийн бодис бие махбодиос гадагшлах замыг сонгоно уу.

1. Бөөрөөр ялгарах
2. Хоол боловсруулах замаар ялгарах
3. Амьсгалын замаар ялгарах
4. Арьсаар ялгарах
5. Хөхний сүүгээр ялгарах

/310./ Ханиалга намдаах эмийг үйлдэлийн чиглэлээр хэрхэн ангилах вэ?

1. Наркозын үйлдэлтэй
2. Төвийн үйлдэлтэй
3. Наркозын бус үйлдэлтэй
4. Захын үйлдэлтэй
5. Ерөнхий үйлдэлтэй

/311./ Токоферолын шимэгдэлт цөсний хүчлийн оролцоотойгоор явагдана. Яагаад гэвэл Магний сульфат нь 12 хуруу гэдэсрүү цөс орохыг идэвхижүүлдэг.

/312./ Ноотроп бэлдмэлүүд нь уураг, липидийн нийлэгжилтийг идэвхижүүлдэг бөгөөд удаан хугацаанд хэрэглэхэд үйлдэлийн үр дүн гарна.

/313./ Ходоод хамгаалах зорилгоор Сукральфатыг хэрэглэнэ. Учир нь шархлааны үхжсэн эдийн уурагтай харилцан үйлчилж өнгөр үүсгэнэ.

/314./ Церукалын олон улсын нэршил нь Metoclopramide бөгөөд янз бүрийн шалтгаантай бөөлжилтийн эсрэг үйлдэл үзүүлнэ.

/315./ Эргокальциферол нь нарны хэт ягаан туяаны нөлөөгөөр арьсанд үүсдэг. Яагаад гэвэл ретинол нь мукополисахаридын нийлэгжилтэнд оролцено

/316./ Усанд уусдаг витаминуудыг сонгоно уу.

1. Ретинол
2. Тиамин
3. Токоферол
4. Никотины хүчил
5. Эргокальциферол

/317./ Хоол боловсруулах замаар ямар үед эм хэрэглэхэд тохиromжгүй байдаг вэ?

1. Бага насны хүүхдэд хэрэглэх
2. Ухаангүй өвчтөнд хэрэглэх
3. Тасралтгүй бөөлжиж буй өвчтөнд хэрэглэх
4. Залгих рефлекс алдагдсан үед
5. Өвчтөн уух аргаас татгалзсан тохиолдолд

/318./ Эмийн тунг бие махбодид үзүүлэх үйлдэлийн хүчээр нь дараах байдаар ангилна

1. Эмчилгээний тун
2. Хордуулах тун
3. Үхлийн тун
4. Бага тун
5. Их тун

/319./ Эмийн бодисыг хоол боловсруулах бус замаар оруулах аргуудыг сонгоно уу.

1. Уух арга
2. Тарих арга
3. Шулзуун гэдсэнд хийх
4. Амьсгалын замаар оруулах
5. Хэлэн дор тавьж шимэх

/320./ Амьсгалын эрхтэн системд нөлөөлөх эмийн зүйлийг хэрхэн ангилах вэ?

1. Бронх өргөсгөх эмийн зүйл
2. Ханиалга намдаах, деконгестант эмийн зүйл
3. Цэр ховхлох эмийн зүйл
4. Амьсгал сэргээх эмийн зүйл

5. Уушгин хаванд хэрэглэх эмийн зүйл
/321./ Эмийн хэлбэрийг сонгоно уу.

1. Хатуу эмийн хэлбэр
2. Зөөлөн эмийн хэлбэр
3. Шингэн эмийн хэлбэр
4. Аэрозоль эмийн хэлбэр
5. Уух эмийн хэлбэр

/322./ Бие махбодид витамин дутагдах шалтгааныг сонгоно уу.

1. Хоол тэжээлд витамин бага байх
2. Витамин гэдэсний ханаар муу шимэгдэх
3. Витамины хэрэгцээ бие махбодид ихсэх
4. Усанд уусдаг витамин
5. Тос, усанд уусдаг витамин

/323./ Салицилатуудыг хэрэглэж байхад ямар гаж нөлөө илрч болох вэ?

- A. Ходоодны шарх үүснэ
- B. Сонсголын мэдрэл гэмтэнэ
- C. Ясжилт өөрчлөгднө
- D. Бөөрний дутагдал үүснэ
- E. Элэгний хатуурал

/324./ Макролидын бүлгийн антибиотикийг сонгоно уу?

- A. Цефотаксим
- B. Примаксин
- C. Азитромицин
- D. Неомицин
- E. Доксициклин

/325./ Артерийн даралт ихсэх өвчний үед эхэлж хэрэглэх эмийг сонгоно уу?

- A. Допегит
- B. Резерпин
- C. Клопамид
- D. Арфонад
- E. Фентоламин

/326./ Тетрациклиныг ходоодны хүчил саармагжуулах эмүүдтэй хамт хэрэглэвэл түүний микробын эсрэг нөлөө буурдаг. Үүний шалтгааныг ол

- A. Тетрациклины шимэгдэлт saatna
- B. Тетрациклины хувирал түргэснэ
- C. Тетрациклины ялгаралт түргэснэ
- D. Тетрациклины тархалтын эзэлхүүн багасна
- E. Тетрациклины ялгаралт багасна.

/327./ Аминофиллины үйлдлийн үргэлжлэх хугацаа хэдэн цаг байдаг вэ?

- A. 1-2 цаг
- B. 2-3 цаг
- C. 3-4 цаг
- D. 6-8 цаг
- E. 8-10 цаг

/328./ Ходоодны шүүрлийг хамгийн сайн дарангуйлах нөлөөтэй бэлдмэлийг нэрлэнэ үү?

- A. Омепразол
- B. Циметидин
- C. Сукралфат
- D. Алмагель
- E. Мезимфорт

/329./ Хөхүүл эхэд хэрэглэж болохгүй эмийг сонгоно уу?

1. Левомицетин
2. Алтны давс
3. Атропин
4. Литийн давс
5. Эрготамин

/330./ Жирэмсэн үед багавтар сөрөг нөлөө үзүүлж болох эмийг сонгоно уу?

1. Метронидазол
2. Мепробамат
3. Эстроген
4. Рифампицин
5. Дифенин

/331./ Антибиотик эмчилгээний үр дүнг ямар аргаар хянах вэ?

1. Цусны шинжилгээ
2. Шээсний шинжилгээ
3. Рентген шинжилгээ
4. Өвөрмөц антителийн титр
5. Биеийн температур, хордлогын шинж

/332./ Антибиотикийн үйлдлийн механизмуудыг сонгоно уу?

1. Микробын эсийн ханын нийлэгжлийг saatуулах
2. Микробын эсийн цитоплазмын мембрани нэвчимхий чанарыг өөрчлөх
3. Рибосомын уургийн нийлэгжлийг saatуулах
4. Нуклейн хүчлийн нийлэгжлийг saatuulaah
5. РНХ-ийн нийлэгжилтийг өөрчилнө

/333./ Гидрокортизоны гаж нөлөө?

1. Нойргүйдэл
2. Хаван
3. Гипокалиеми
4. Остеопороз
5. Эйфори

/334./ Фармакокинетикийн үндсэн ухагдахууныг дурьдана уу?

1. Биохүрэхүй (F)
2. Тархалтын эзэлхүүн (Vd)
3. Элиминаци, клиренс (Cl)
4. Хагас элиминацын хугацаа (t_{1/2})
5. Урагтай холбогдолт

/335./ Хеликобактерийн эсрэг нөлөөт эмүүдийг сонгоно уу?

1. Тетрациклин
2. Амоксациллин
3. Мономицин
4. Метронидазол
5. Ампициллин

/336./ Жирэмсэн үед хэрэглэж болохгүй антибиотикуудыг сонгоно уу?

1. Стрептомицин
2. Тrimetoprim
3. Тетрациклин
4. Гентамицин
5. Цефазолин

/337./ Эмийн гаж нөлөөний шалтгааныг нэрлэнэ үү?

1. Өвчтөн нэг дор олон нэр төрлийн эм хэрэглэх
2. Өвчтөн эмийг зохисгүйгээр дур мэдэн хэрэглэх
3. Эмийн зааваргүйгээр эм хэрэглэх

4. Биологийн өндөр идэвхтэй эмт бодисын хэрэглээ өссөн
5. Биед үзүүлэх гадаад хүчин зүйлийн нөлөө ихэссэн

/338./ Бисептолыг хэрэглэж болохгүй цээрлэлийг сонгоно уу?

1. Бөөрний илэрхий өөрчлөлттэй
2. Жирэмсэн үе
3. Элэгний илэрхий өөрчлөлттэй
4. 1 сар хүртэлх насны хүүхэд
5. Түрүү булчирхайн үрэвсэл

/339./ Каптоприлийн гаж нөлөөг сонгоно уу?

1. Арьсны тууралт
2. Ханиалгах
3. Амтны мэдрэмж өөрчлөгдөх
4. Хамар битүүрэх
5. Зүрх дэлсэх

/340./ Аскорбины хүчлийн үйлдлүүдийг сонгоно уу.

1. Исэлдэн ангижрах процессыг зохицуулна
2. Стероид гормоны үүсэлтийг дэмжинэ.
3. Судасны ханын нэвчимтгий чанарыг багасгана
4. Бие махбодыг гадны халдварт тэсвэртэй болгоно.
5. Антиоксидант

/341./ Бензилпенициллиний гаж нөлөө

- A. Чонон хөрвөс, анафлаксын шок
- B. Чих дүлийрэх
- C. Квинкийн хаван, таргалалт
- D. Шүд шарлах
- E. Анафлаксийн шок, шарлалт

/342./ Клиникийн фармакодинамик гэж юу вэ?

А. Бие махбодийн харилцан үйлчлэлийн дунд илрэх хариу урвалыг ерөнхийд нь фармакодинамик гэнэ.

Б. Эмийн бодис ба бие махбодийн харилцан үйлчлэлийн дунд илрэх хариу урвалыг ерөнхийд нь фармакодинамик гэнэ.

С. Эмийн бодисын харилцан үйлчлэлийн дунд илрэх хариу урвалыг ерөнхийд нь фармакодинамик гэнэ.

Д. Эмийн бодис ба бие махбодийн харилцан үйлчлэлийн дунд илрэхгүй хариу урвалыг ерөнхийд нь фармакодинамик гэнэ.

Е. Эмийн бодис ба бие махбодийн харилцан үйлчлэлийн дунд илэрч болох хариу урвалыг ерөнхийд нь фармакодинамик гэнэ.

/343./ Ацидоз гэж юуг хэлэх вэ?

- A. Шүлтлэг зүйл биед хуримтлагдахыг хэлнэ
- B. Хүчиллэг, шүлтлэг аль аль хуримтлагдахыг хэлнэ
- C. Төрөл бүрийн эмгэгийн үед хүчиллэг хуримтлагдахыг хэлнэ
- D. Бие организмд бодисын солилцооны эцсийн бүтээгдэхүүн хуримтлагдахыг хэлнэ
- E. Төрөл бүрийн өвчний үед шүлтлэг хуримтлагдахыг хэлнэ

/344./ Зүрхний дутагдлын үед ямар эмээр эмчилгээг эхлэх вэ?

- A. Судас өргөсгөх эмээр
- B. Диуретикээр
- C. Инотроп нөлөөт эмээр
- D. Артерийн даралт бууруулах эмээр
- E. Төвийн үйлдэлтэй эмээр

/345./ Антибиотик хэрэглэсний улмаас хүүхдийн ясжилт өөрчлөгдөн шүдний өнгө нь шарлажээ. Дараах антибиотикуудаас алийг нь хэрэглэж байсан байх вэ?

- A. Ампициллин
- B. Тетрациклин
- C. Гентамицин
- D. Левомицетин
- E. Цефазолин

/346./ Гуурсан хоолойн багтрааг эмчлэх эмийн эмчилгээний үндсэн чиглэлийг олно уу?

- A. Тамхи татахыг хориглох
- B. Бронхийн агшилтыг сулруулах, харшил суурьтай үрэвслийг намдаах
- C. Үрэвслийг намдаах
- D. Харшлын суурьтай үрэвслийг намдаах
- E. Харшлыг намдаах